



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/40/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт сум

2023 он

Миндүг Аудит ХХК

Гүйцэтгэх захирал С.Энхтөр

Утас: 95957791

Цахим хаяг: director@mindug.mn

Аудитын менежер Ц.Номингоо

Утас: 90098901

Цахим хаяг: соо@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.1 Төлбөрийн акт	14
5.2 Зөвлөмж	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Мөнххаан сумын Засаг даргын тамгын газрын ДАРГА
С.ОЮУНЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй байна.

Тус байгууллагын тайлант оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 738,650.5 мянган төгрөг байхаар тооцож дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 675.8 мянган төгрөгөөр бууруулан 737,974.7 мянган төгрөгөөр баталсан.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхэд нийт 737,974.7 мянган төгрөг төсөвлөж, гүйцэтгэлээр 703,863.5 мянган төгрөгийн санхүүжилт хийгдсэн.

Бусад асуудлын хэсэг

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Үйл ажиллагааны тайлан, бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	91,664,875.00	101,817,323.00
33	АВЛАГА	1,844,000.00	8,563,028.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	39,080.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	8,523,948.00
335	Бусад авлага	1,844,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	1,844,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	89,820,875.00	93,254,295.00
354	Хангамжийн материал	42,695,875.00	46,129,295.00
35410	Бичиг хэргийн материал	2,185,045.00	3,025,865.00
35420	Аж ахуйн материал	9,829,630.00	9,829,630.00
35430	Сэлбэг хэрэгсэл	6,000,000.00	6,000,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	660,000.00
35450	Барилгын засварын материал	2,400,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	22,281,200.00	26,613,800.00
35600	Мал амьтад	47,125,000.00	47,125,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,798,148,640.51	2,205,725,363.93
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,798,148,640.51	2,205,725,363.93
392	Биет хөрөнгө	1,792,694,640.61	2,199,104,280.62
39201	Барилга, байгууламж, орон сууц	612,427,397.97	824,427,397.97
39202	Хуримтлагдсан элэгдэл	(59,561,442.68)	(93,922,376.48)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	329,506,800.00	425,106,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(179,585,899.51)	(214,979,432.71)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	89,687,599.40	151,671,149.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(28,436,355.05)	(56,991,937.17)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	86,097,476.77	86,526,976.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21,545,991.82)	(32,574,542.07)
39209	Зам, гүүрийн байгууламж	510,268,816.00	510,268,816.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(33,103,011.68)	(57,930,270.44)
39214	Бусад үндсэн хөрөнгө	838,820,084.50	1,083,749,009.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	(352,080,833.29)	(426,447,310.15)
39217	Ном	200,000.00	200,000.00
393	Биет бус хөрөнгө	5,453,999.90	6,621,083.31
39301	Програм хангамж	2,386,500.00	2,386,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,946,500.10)	(2,386,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,014,000.00	7,009,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	(387,916.69)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,889,813,515.51	2,307,542,686.93
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,889,813,515.51	2,307,542,686.93
51	Засгийн газрын хувь оролцоо	1,889,813,515.51	2,307,542,686.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	271,947,945.17	271,947,945.17
51101	Өмч: - төрийн	271,947,945.17	271,947,945.17
512	Хуримтлагдсан үр дүн	1,546,233,428.09	1,963,962,599.51
51210	Өмнөх үеийн үр дүн	1,546,233,428.09	1,546,233,428.09
51220	Тайлант үеийн үр дүн	-	417,729,171.42
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	71,632,142.25	71,632,142.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,889,813,515.51	2,307,542,686.93

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,188,001,318.00	1,439,115,175.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	423,211,403.50	572,132,475.00
120	Нийтлэг татварын бус орлого	423,211,403.50	572,132,475.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	764,789,914.50	866,982,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	210,070,214.50	147,478,800.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	32,035,200.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	75,695,014.50	144,218,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,340,000.00	3,260,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	554,719,700.00	719,503,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	554,719,700.00	719,503,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	770,697,781.86	1,021,386,003.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	770,697,781.86	1,021,386,003.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	732,080,626.37	991,433,364.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	285,315,628.94	285,475,590.50
210101	Үндсэн цалин	234,194,088.32	230,954,434.38
210102	Нэмэгдэл	16,318,800.00	43,385,379.32
210104	Урамшуулал	3,450,000.00	11,135,776.80
210105	Гэрээт ажлын хөлс	31,352,740.62	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,548,510.91	38,768,770.35
210201	Тэтгэврийн даатгал	29,643,436.02	27,147,860.38
210202	Тэтгэмжийн даатгал	2,922,574.89	2,862,950.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,877,634.96	2,420,599.48
210204	Ажилгүйдлийн даатгал	904,907.26	614,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,199,957.78	5,722,760.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,947,695.07	28,540,857.79
210301	Гэрэл, цахилгаан	12,283,925.77	18,229,665.89
210302	Түлш, халаалт	10,163,769.30	9,711,191.90
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	49,233,792.00	51,140,456.00
210401	Бичиг хэрэг	3,404,550.00	5,900,323.00
210402	Тээвэр, шатахуун	36,924,777.00	35,304,067.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,870,390.00	2,748,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	900,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,034,075.00	6,287,266.00
2105	Нормативт зардал	14,352,000.00	400,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,050,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	302,000.00	400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,279,950.00	17,554,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,053,450.00	11,014,400.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	394,800.00
210604	Урсгал засвар	9,226,500.00	6,145,700.00
2107	Томилолт, зочны зардал	2,702,000.00	3,482,000.00
210702	Дотоод албан томилолт	2,702,000.00	3,482,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,866,293.00	190,977,880.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	60,906,680.00	190,744,830.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	159,306.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	64,350.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	665,550.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	34,500.00	58,700.00
210807	Газрын төлбөр	35,907.00	110,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	230,834,756.45	375,092,909.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	131,632,000.00	154,141,948.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,402,000.00	11,060,210.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	93,800,756.45	209,890,751.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,617,155.49	29,952,639.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,743,400.00	14,312,265.76
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6,193,400.00	8,512,937.76
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	4,803,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	550,000.00	995,828.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	31,873,755.49	15,640,373.60
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,873,755.49	15,640,373.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	417,303,536.14	417,729,171.42
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	417,303,536.14	417,729,171.42

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	764,789,914.50	868,826,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	764,789,914.50	868,826,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	210,070,214.50	149,322,800.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	32,035,200.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	75,695,014.50	146,062,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,340,000.00	3,260,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	554,719,700.00	719,503,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	554,719,700.00	719,503,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	741,689,914.50	823,491,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	741,689,914.50	823,491,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	701,228,759.01	784,652,266.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	285,315,628.94	285,447,341.16

210101	Үндсэн цалин	237,853,843.07	230,302,255.68
210102	Нэмэгдэл	16,318,800.00	41,294,728.68
210104	Урамшуулал	3,450,000.00	13,850,356.80
210105	Гэрээт ажлын хөлс	27,692,985.87	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,109,500.00	38,836,099.69
210201	Тэтгэврийн даатгал	28,630,000.00	26,408,099.99
210202	Тэтгэмжийн даатгал	3,066,000.00	3,106,699.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,856,000.00	2,485,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	891,500.00	621,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,666,000.00	6,214,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,947,695.07	29,600,817.79
210301	Гэрэл, цахилгаан	12,283,925.77	18,229,665.89
210302	Түлш, халаалт	10,163,769.30	10,771,151.90
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	49,435,792.00	52,369,266.00
210401	Бичиг хэрэг	3,796,550.00	4,228,100.00
210402	Тээвэр, шатахуун	36,924,777.00	38,012,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,870,390.00	2,748,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	900,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,844,075.00	6,479,866.00
2105	Нормативт зардал	14,866,000.00	400,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,900,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	966,000.00	400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,132,650.00	21,440,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,906,150.00	10,100,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	394,800.00
210604	Урсгал засвар	9,226,500.00	10,945,700.00
2107	Томилолт, зочны зардал	2,702,000.00	3,482,000.00
210702	Дотоод албан томилолт	2,702,000.00	3,482,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	81,580,493.00	189,482,280.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	80,620,880.00	189,249,230.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	159,306.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	64,350.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	665,550.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	34,500.00	58,700.00
210807	Газрын төлбөр	35,907.00	110,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	173,139,000.00	163,593,962.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	167,737,000.00	153,594,752.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,402,000.00	9,999,210.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,461,155.49	38,839,433.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,743,400.00	14,675,111.76
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6,193,400.00	8,875,783.76
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	4,803,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	550,000.00	995,828.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	33,717,755.49	24,164,321.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	23,100,000.00	45,335,000.00

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	23,100,000.00	45,335,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,100,000.00	45,335,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	23,100,000.00	45,335,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	23,100,000.00	45,335,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(23,100,000.00)	(45,335,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	271,947,945.17	74,057,666.98	847,843,277.29	1,193,848,889.44
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	2,425,524.73	2,425,524.73
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	271,947,945.17	74,057,666.98	850,268,802.02	1,196,274,414.17
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	280,547,965.94	280,547,965.94
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	271,947,945.17	71,632,142.25	1,546,233,428.09	1,889,813,515.51
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	271,947,945.17	71,632,142.25	1,546,233,428.09	1,889,813,515.51
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	271,947,945.17	71,632,142.25	1,546,233,428.09	1,889,813,515.51
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	417,729,171.42	417,729,171.42
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	271,947,945.17	71,632,142.25	1,963,962,599.51	2,307,542,686.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	737,974,700.00	703,863,526.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	737,974,700.00	703,863,526.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	723,155,700.00	689,188,414.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	313,620,200.00	285,447,341.16
210101	Үндсэн цалин	242,653,100.00	230,302,255.68
210102	Нэмэгдэл	56,949,400.00	41,294,728.68
210104	Урамшуулал	14,017,700.00	13,850,356.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,835,800.00	38,836,099.69
210201	Тэтгэврийн даатгал	26,408,100.00	26,408,099.99
210202	Тэтгэмжийн даатгал	3,106,900.00	3,106,699.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,485,200.00	2,485,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	621,200.00	621,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,214,400.00	6,214,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,265,500.00	29,600,817.79
210301	Гэрэл, цахилгаан	20,790,500.00	18,229,665.89
210302	Түлш, халаалт	10,875,000.00	10,771,151.90
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,218,600.00	46,135,266.00
210401	Бичиг хэрэг	4,260,000.00	4,228,100.00
210402	Тээвэр, шатахуун	32,250,000.00	32,218,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,308,800.00	2,308,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	900,000.00	900,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,499,800.00	6,479,866.00
2105	Нормативт зардал	402,000.00	400,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	402,000.00	400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	51,603,500.00	51,505,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	40,100,000.00	40,100,000.00
210602	Тавилга	250,000.00	210,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	250,000.00	250,000.00
210604	Урсгал засвар	11,003,500.00	10,945,700.00

2107	Томилолт, зочны зардал	3,102,000.00	3,074,000.00
210702	Дотоод албан томилолт	3,102,000.00	3,074,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	71,852,500.00	70,230,280.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,005,000.00	68,002,230.00
210803	Даатгалын үйлчилгээ	765,000.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	635,600.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	231,000.00	58,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,995,000.00	1,995,000.00
210807	Газрын төлбөр	110,000.00	110,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	60,900.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	165,255,600.00	163,958,910.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	155,255,500.00	153,959,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,000,100.00	9,999,210.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,819,000.00	14,675,111.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,819,000.00	14,675,111.76
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	8,996,400.00	8,875,783.76
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,803,500.00	4,803,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,019,100.00	995,828.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	737,725,000.00	719,503,900.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	737,725,000.00	719,503,900.00
132001	Орон нутгийн төсвөөс	737,725,000.00	719,503,900.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23.00	23.00
620001	Удирдах ажилтан	3.00	3.00
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	23.00	23.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	5.00	5.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.00	7.00
650010	Гэрээт ажилтан	4.00	4.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7.00	7.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		140,798,852.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		140,798,852.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		140,798,852.00
2104	Хангамж, бараа материалын зардал		6,234,000.00
210402	Тээвэр, шатахуун		5,794,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		440,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		144,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		144,800.00
2107	Томилолт, зочны зардал		408,000.00
210702	Дотоод албан томилолт		408,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		124,377,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		124,377,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	9,635,052.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		9,635,052.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	149,322,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		149,322,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		146,062,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3,260,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Засаг даргын тамгын газар нь “Иргэн төвтэй үр дүнд суурилсан, төр иргэний харилцаанд итгэл хүлээсэн төрийн үйлчилгээг шуурхай, ил тод хүргэж, сумынхаа тогтвортой хөгжлийг хангах” зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Сумын нийгэм, эдийн засгийг хөгжүүлсэн өрсөлдөх чадвартай төрийн захиргааны тэргүүлэгч байгууллага болох алсын хараатай байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө бага байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 417,729.2 мянган төгрөгөөр буюу 22.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1,844.0	8,563.0	6,719.03
Бараа материал	89,820.9	93,254.3	3,433.42
Үндсэн хөрөнгө	1,798,148.6	2,205,725.4	407,576.72
Нийт хөрөнгийн дүн	1,889,813.5	2,307,542.7	417,729.17
Засгийн газрын хувь оролцоо	1,889,813.5	2,307,542.7	417,729.17
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,889,813.5	2,307,542.7	417,729.17

- Авлага 6,719.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны татаас санхүүжилтийн авлага 8,523.9 мянга, ажиллагсдаас авах авлага 39.1 мянга, нийт 8,563.0 мянган төгрөгийн авлага үүсэж, 2011 оны цэвэр бохир усны санхүүжилт хийх авлагын үлдэгдэл 1,844.0 төгрөгийг барагдуулсан үр дүнтэй байна.
- Бараа материалын үлдэгдэл 3,433.4 мянган төгрөгөөр өссөн ба бичиг хэргийн материал 10,088.8 мянган төгрөгийн орлого авч 9,248.0 мянган төгрөгийн материал зарцуулсан, түлш, шатахууны зардалд 64,258.6 мянган төгрөгийг зарцуулж, дансны үлдэгдэл 660.0 төгрөг болсон, барилгын засварын материал 35,737.0 мянган төгрөгөөр орлогод авч 38,137.0 мянган төгрөгийн материал зарцуулсан, бусад хангамжийн материалд 148,158.2 мянган төгрөгийн орлого авч, 143,825.6 мянган төгрөгийг зарцуулсан ба нийтдээ 258,902.6 мянган төгрөгийн бараа материалыг орлогод авснаас 255,469.2 мянган төгрөгийн материал зарцуулсан байна. Бичиг хэргийн материал 840.8 мянган төгрөг, түлш шатахуун 660.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 4,332.6 мянган төгрөгөөр тус тус өссөн бөгөөд барилгын засварын материал 2,400.0 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.
- Үндсэн хөрөнгө 407,576.7 мянган төгрөг буюу өмнөх оноос 22.7 хувиар өссөн байна. 45,335.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан ба Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн 523,881.5 мянган төгрөгийн хөрөнгө болон 48,251.0 мянган төгрөгийн НҮБ-ийн хөгжлийн сангаас санхүүжсэн Залуусын хөгжлийн төвийн тоног төхөөрөмж, нийт 572,132.5 мянган төгрөгийн хандивын хөрөнгийг ЗДТГ-ын хөрөнгөөр бүртгэн орлогод хүлээн авч, 530.5 мянган төгрөгийн хөрөнгө акталсан. Тайлант оны хуримтлагдсан элэгдлийн зардал 209,890.8 мянган төгрөг байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын тайлант оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 738,650.5 мянган төгрөг байхаар тооцож дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 675.8 мянган төгрөгөөр бууруулан 737,974.7 мянган төгрөгөөр баталсан.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 737,974.7 мянган төгрөгийг төсөвлөж, төсвийн нийт зардлыг мөн 737,974.7 мянган төгрөгөөр төсөвлөсөн ба гүйцэтгэл нь 703,863.5 мянган төгрөг буюу 95.4 хувийн биелэлттэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мян.төг/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагаа	723,155.7	689,188.4	-33,967.3	95.3%
2	80714 Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	8,996.4	8,875.8	-120.6	98.7%
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	5,822.6	5,799.3	-23.3	99.6%
НИЙТ		737,974.7	703,863.5	34,111.2	95.4%

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 34,111.2 мянган төгрөгийн төсөв хэмнэгдсэн бөгөөд үүнээс хөдөө аж ахуйн тасагт 2 орон тоо дутуу ажилласанаас цалингийн зардал буурсантай холбоотой нөлөөлөл ажээ.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нийт нэмэлт санхүүжилтийн орлого нь 149,322.8 мянган төгрөг төвлөрсөн байна. Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө болох 146,062.8 мянган төгрөгийн санхүүжилт нь Сайн хашаа төслийн санхүүжилт, Сангийн сайд багцаас Тэрбум мод аяны хүрээнд олгосон санхүүжилт ба усны орлого 1,890.0 мянган төгрөг, тендерийн урилгын орлого 450.0 мянган төгрөг, 920.0 мянган төгрөгийн түрээсийн орлого нийт 3,260.0 мянган төгрөгийн орлого бүрдсэн байна.

Худгийн ажилчдын цалин урамшуулал болон худгийн засварт 9,635.1 мянган төгрөг, сайн хашаа төсөл болон тэрбум модны аяны хүрээнд 124,377.0 мянган төгрөгийн хашааг барьж байгуулсан байна. Цагдаагийн тасагтай хамтран хэрэгжүүлсэн хориотой ан аяны хүрээнд цагаан зээрийн эргүүлд явсан албан хаагчдын томилолтын зардалд 408.0 мянган төгрөг, хөдөлмөр хамгааллын хувцас 144.8 мянган төгрөг, худгийн интернэт төхөөрөмжийн сунгалт, төхөөрөмжийн үнэ 440.0 мянган төгрөг, мал тооллого, сэг зэм устгал, хог түрэлтийн шатахууны зардалд 5,794.0 мянган төгрөг нийт 140,798.9 мянган төгрөгийг зарцуулжээ. Үлдэгдэл 8,523.9 мянган төгрөгийн үлдэгдлийг авлагын дансанд бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Миндүг аудит ХХК–ны аудитор Б.Бүзмаа гүйцэтгэж, туслах аудитор Т.Цагаанбаяр, чанарын хяналтыг аудитор С.Энхтөр, хяналтыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Засаг даргын Тамгын Газар нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Миндүг аудит ХХК–д 2023 оны 01 дүгээр сарын 25 -ны өдрийн 03/33 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 1.0 хувиар буюу 7,725.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,407.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹, 15.2.3²-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд 1,906.7-5,945.7 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Дээрх зардлууд өмнөх оноос өссөн учир шалтгааныг авч үзвэл:

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

² сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

- Гэрэл цахилгаан 5,945.7 мянган төгрөгөөр өссөн нь шинээр наадмын талбай, байгууллагын гадна гэрэлтүүлэг, худаг, хашаа байгуулсантай холбоотой өсөлт байна.
- Бараа материалын зардал: Бичиг хэргийн зардал 2,495.8 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын үнийн өсөлтөөс хамаарчээ.
- Томилолтын зардал 780.0 мянган төгрөгөөр өссөн. Энэ нь Цагдаагийн байгууллагатай хамтран явуулсан хориотой ан аяны хүрээнд гарсан томилолтын зардал ажээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант хугацаанд оруулбал зохих 68 мэдээллээс, хугацаандаа оруулсан 52 мэдээлэл хугацаандаа мэдээлэгдсэн байна. Хугацаа хоцорсон 202,766.9 мянган төгрөгийн 16 мэдээлэл байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах энэхүү алдааг гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Засаг даргын тамгын газар нь бусад хууль тогтоомжийн хүрээнд материаллаг асуудал илэрсэнгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Засаг даргын тамгын газар нь 2022 онд завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн бус хэрэгжүүлж 58 хувьтай биелүүлсэн байна.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 75 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгааг стандартын дагуу тайлагнахыг зөвлөсөн боловч уг зөвлөмжийн дагуу залруулга хийгээгүй байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Залруулга	5	53,184.1	5	53,184.1	100
Зөвлөмж	4	57,371.4	-	-	-
Албан шаардлага	3	25,887.7	3	25,887.7	100
Төлбөрийн акт	1	150.0	1	150.0	100
Нийт дүн	13	136,593.2	13	79,221.8	58

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 583,246.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс нийгмийн даатгал илүү суутгаж цалин дутуу олгосон 562.5 мянган төгрөгийн алдааг залруулсан, 265,420.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг цахим баримтаар баталгаажуулаагүй, үндсэн хөрөнгийн дансанд 11,401.4 мянган төгрөгийн хасах үлдэгдэлтэй хөрөнгө бүртгэж стандартын бус бүртгэл хөтөлж, үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийг бууруулан бүртгэсэн алдаа гаргасан. Эдгээр алдаа зөрчлүүдэд зөвлөмж хүргүүлсэн.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 295,861.5 мянган төгрөгийн үнэ бүхий 85 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ зөрчлийг өмнөх аудитаар илрүүлж зөвлөмж хүргүүлсэн боловч арга хэмжээ авч ажиллаагүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин 10,000.0 мянган төгрөгийн хөшөө барьж байгуулсан алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангаагүй алдаа, зөрчилд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

5.1 Албан шаардлага.

5.1.1 Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 295,861.5 мянган төгрөгийн үнэ бүхий 90 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага хүргүүлэв.

5.1.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин 10,000.0 мянган төгрөгийн хөшөө барьж байгуулсан.

Шийдвэрлэсэн: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.1 заалтыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

5.2.1 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн дансанд 11,401.4 мянган төгрөгийн хасах үлдэгдэл бүхий хөрөнгийг бүртгэж, үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийг бууруулан бүртгэж тайлагнасан алдаа байгаа нь НББ-ийн тухай хуулийн 5.1.3.жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4.үнэн зөв байх; зүйл заалтыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлийг НББ-ийн тухай хуулийн 5-р зүйл заалтын дагуу үнэн зөв бүртгэх.

5.2.2 Бусад хууль тогтоомжтой холбоотой асуудлаар

Илрүүлэлт: Худалдан авалтын ажил гүйлгээний баримтыг /<https://ebarimt.mn/> цахим төлбөрийн системд бүрэн шивэгдээгүй байхад зарлагын гүйлгээ хийгдэж байна.

Өгсөн зөвлөмж:

НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 3.1-д заасны дагуу албан татвар төлөгчийн хийсэн төлбөр тооцооны мэдээллийг хэрэглэгчийн системд тухай бүр бүртгэнэ", НББ-ийн тухай хуулийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг мөрдөн, цахим баримтын бүрдлийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
НД дутуу суутгаж цалин илүү олгосон	1	562.5			1	562.5	1	562.5				
Дүн	1	562.5			1	562.5	1	562.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхны өртөгөө нөхсөн хөрөнгийг стандартын дагуу бүртгээгүй	1				1							
Санхүүгийн тайланд хасах дансны үлдэх өртөгтэй хөрөнгө тусгасан	1	11,401.4					1	11,401.4				
Цахим баримтаар баталгаажуулаагүй ажил үйлгээ хийгдсэн	1						1					
Дүн	3	11,401.4			1		2	11,401.4				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
www.shilendans.gov.mn цахим хуудсанд 13 мэдээ хугацаа хоцроож мэдээлсэн	1						1	
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн хууль зөрчин хөшөө барьсан	1	10,000.0			1	10,000.0		
Дүн	1	10,000.0			1	10,000.0		
Нийт дүн	1	10,000.0			1	10,000.0	1	